



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 24 өдөр

Дугаар А/367

Чингис хот

Цэцэрлэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5-ын "а", Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Боловсрол, соёл, урлагийн газрын санал, дүгнэлтийг үндэслэн Хэрлэн сумын Х цэцэрлэгийг байгуулсугай.

2. Хэрлэн сумын Х цэцэрлэгийн сургалт хүмүүжлийн ажлыг холбогдох хууль, журмын дагуу мэргэжил, арга зүйн зөвлөгөө, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Боловсрол, соёл, урлагийн газар /С.Мөнхцэцэг/, дэмжлэг үзүүлж, хамтарч ажиллахыг Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын захирагч /Б.Энх-Эрдэнэ/ нарт тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс/ Г.Лхагвахатан/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ